

Мэдээлэл

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, ӨМЧЛҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДАХИН ДУУДЛАГА ХУДАЛДАА 2 БАЙРШИЛД ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/225 дугаар захирамжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг интернетээр 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдөр “Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар 2 байршилд дуудлага худалдаа зохион байгуулагдлаа.

1. Сүмбэр сум 3-р багт “Амтат зоог” зоогийн газраас урагш авто замын зүүн талд зарлагдсан 1500 м² газарт 1 оролцогч буюу иргэн Н.Гэсэрбаатар бүртгүүлж ганц оролцогч бүртгүүлсэн болон мөн өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт тог тасарч системийн цагт зөрөө гарсан зэрэг шалтгааны улмаас тус дуудлага худалдаа хүчингүй болсон болно.

2. Сүмбэр сумын 2 дугаар багт “М-Ойл” ХХК-ий ШТС-ын зүүн талд зарлагдсан газарт оролцогч бүртгүүлээгүй тул мөн хүчингүй болсон.

2018-68 дахь дуудлага худалдаанд 1 оролцогч бүртгүүлсэн байдал

2018-69 дэх дуудлага худалдаанд оролцогч бүртгүүлээгүй байгаа байдал

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР